

**АНГЛИ, МОНГОЛ, ТҮРЭГ ХЭЛНИЙ СЭДЭГЧИЙН ОНООЛТ БА
ӨГҮҮЛЭГДЭХҮҮН СЭДЭГЧИЙН ХАРЬЦАА**

М. Ууганбаяр *

Англи хэлний баримтаас харахад,
The boy opened the door with the key
Хөвгүүн хаалга түлхүүрээр нээв.
The key opened the door
Түлхүүр хаалга нээв.
The door opened
Хаалга нээв.

Эдгээр өгүүлбэрт the door гэсэн махбод нээгдэж байгаа юм тусагдахуун буюу өртөх сэдэгч болж байгаа бөгөөд the key гэсэн махбод эхний хоёр өгүүлбэрт бүтцийн байрлалын ялгаанаас үл хамаарч аль алинд нь хэрэгсэх сэдэгч болж байна. Мөн эдгээр жишээнд эхний өгүүлбэрийн the boy хэмээх өгүүлэгдэхүүн үйлдэх сэдэгч болох ба хоёрдахь өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн the key нь хэрэгсэх сэдэгч болж, сүүлийн өгүүлбэрийн the door гэх өгүүлэгдэхүүн өртөх сэдэгч болж байна. Эл гурван өгүүлбэрийн утга зүй open нээх хэмээх үйл үгийн утга хийгээд энэхүү үйл үг тусагдахууныг хэрхэн сонгож байгаа түүнчлэн төрөл бүрийн сонголтын боломжоос хамаарч өгүүлэгдэхүүн тусагдахуунд оноосон сэдэгчээс үүдэх ажээ. /Фромкин Родман Хиэмс 2003:193/

Өөрөөр хэлбэл сэдэгчид үндэслэгчдийг оноохын тухайд үйл үг ба нөхөгч гэсэн хэлбэрийн Y-зураас бүрдүүлэгчдээс нөхөгчийн сэдэгч нь үйл үгийн утга зүйн шинжээр тодорхойлогдож байна. Энд үйл үг дотоод үндэслэгч юм уу нөхөгчдөө сэдэгчийг шууд оноож буй юм. Жишээ нь бидний доор жагсааж буй баримтад хэв шинжлэг сэдэгч, өртөх сэдэгчид хамаатах тодотгогчийн хэлхэц бүрдүүлэгчидтэй холбогдож байна.

[The FBI] arrested [Larry Luckless]
[agent] [theme]
[Холбооны мөрдөх товчоо] [Ларри Лаклэсийг] баривчлав
[Үйлдэх сэдэгч] [өртөх сэдэгч]
[The suspect] received [a caution]
[recipient] [theme]
[Сэжигтэн] [сануулга] хүлээн авав.
[Хүлээх сэдэгч] [өртөх сэдэгч]

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

[The audience] enjoyed [the play]
 [experiencer] [theme]
 [Үзэгчид] [жүжгийг] таалав
 [Турших сэдэгч][өртөх сэдэгч]
 [The president] went [to Boston]
 [theme] [goal]
 [Ерөнхийлөгч] [Бостон руу] явав.
 [Өртөх сэдэгч] [зорих сэдэгч] /Рэдфорд 1997: 164/

Бидний дээр авч үзсэн бүх жишээнд өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн буюу эхний нэрийн хэлхэц нь янз бүрийн сэдэгч болж байна.

Маранц Чомски нар үйл үг ба нөхөгч гэсэн бүтэц буюу үйл үг зурааст бүрдүүлэгч бүхэлдээ гадаад үндэслэгч юм уу өгүүлэгдэхүүндээ оноож буй сэдэгчийг тодорхойлно гэж үзсэн ба

John threw a ball
 John threw a fit
 Жон бөмбөг шидэв
 Жон дэлбэртлээ уурлав
 John broke the window
 John broke his arm
 Жон цонх хагалав
 Жон гараа хугалав


Дээрх баримтын эхний хоёр өгүүлбэрт threw хэмээх үйл үгийн өгүүлэгдэхүүн болох John гэх үг нь өөр өөр сэдэгчийн үүргийг гүйцэтгэх ба threw a ball-ийн хувьд үйлдэх сэдэгч болж threw a fit-ийн тухайд турших сэдэгч болж байна. Үүнтэй адилаар дараагийн хоёр өгүүлбэрээс broke хэмээх үйл үгийн өгүүлэгдэхүүн нь болж байгаа John хэмээх үг сүүлийн хоёр өгүүлбэрт үйлдэх сэдэгч болж байгаа ч дөрөвдөхь жишээнд хугалах гэдэг үйлдэл тохиолдол заах утгаар бол турших сэдэгчийн үүрэг хүлээх нь илүү зөв тайлбар болно гээд эдгээр жишээнд тулгуурлан Маранц Чомски нар өгүүлэгдэхүүний утгын үүрэг нь дан ганц үйл үгээр бус үйл үг ба нөхөгч гэсэн бүтэц буюу үйл үг зурааст бүтцээр тодорхойлогддог хэмээн үзжээ. /Маранц 1984:23, Чомски 1986:59-60, Рэдфорд 1988 :384-388.1997: 164-166 /

Сэдэгчийг үндэслэгчид үгийн сангийн айн холболтын үйл явцаар /merger with a lexical category/ оноодог ба англи хэлний He throw the ball гэх жишээнээс харвал throw гэх үйл үг the хэмээх тодосгогчийг ball гэсэн нэр үгтэй холбох the ball гэх тодосгогчийн хэлхэцтэй холбогдож throw the ball гэх үйл үгийн зурааст бүтэцийг үүсгэнэ. Энэхүү холбох үйл ажиллагааны үр дүнд the ball хэмээх тодосгогчийн хэлхэц нь throw үйл үгийн өртөх сэдэгчийн үндэслэгчид оногдоно.

Мөн throw the ball гэх үйл үгийн зурааст бүтэц he гэх төлөөний нэрийн тодосгогчтой холбогдож улмаар he гэх өгүүлэгдэхүүнд throw the ball хэмээх үйл үгийн зурааст бүтцийн үйлдэх сэдэгчийн үндэслэгч оногдоно. /Рэдфорд 1997: 164-166/

Эл үйлийн хэлхэцийг зураглан харуулбал дараах байдалтай болно.

цөм нь нэмэлтүүддээ шууд тэмдэглэгээ хийдэг. Жишээлбэл, унш- гэдэг үйл үг юм гэсэн нэмэлтдээ Ө-тэмдэглэгээ хийдэг. Гэвч энэ нь өгүүлэгдэхүүний үүргүүдээ хэрхэн хүлээн авдгийг бидэнд тодорхой хэлж өгдөггүй. Өгүүлэгдэхүүн нь үйлийн хэлцийн тухайлцын байранд байрладаг хийгээд цөм болсон үйл үгтэй эгч дүүгийн харьцаанд байдаггүй гэсэн тодорхойлолтыг эргэн санахул




болно. Өгүүлэгдэхүүн нь нэмэлтүүдээ бодоход цөм үйл үгээс хол орших бөгөөд өгүүлэгдэхүүн нь ямар үүргүүдийг хүлээхийг зөвхөн цөм ганцаараа тодорхойлдоггүй гэдгээс үүнийг харж болно. Заримдаа өгүүлэгдэхүүний үүрэг нь цөм нэмэлт хоёрын нийлэмжээр тодорхойлогддог. Жишээ нь :

Дорж цонх хагалав гэсэн өгүүлбэрт Дорж нь үйлийг биечлэн үйлдсэн хүн болж үйлдэгч Ө- үүрэг хүлээж байна. Гэтэл нэмэлтийг солиход өгүүлэгдэхүүнд өөр боломжит Ө-үүрэг оногдож байна. Жишээ нь: Дорж гараа хугалсан гэсэн өгүүлбэрт Дорж нь түрүүчийн адил үйлдэгч өөрөөр хэлбэл Дорж нь өөрийнхөө гарыг санаатай хугалсан байж болох боловч илүү нийтлэг тайлбар нь Дорж нь өртөгч үүрэг хүлээж ямар нэгэн юманд өртсөн хүн мэтээр ойлгогдож өөрөөр хэлбэл түүний гар нь хугарсан болж таарч байна. Гэтэл ийм тайлбар нь цонх хагарсан тухай өгүүлбэрт байж болохгүй бөгөөд үйл үгийн нэмэлт өөрчлөгдөх нь өгүүлэгдэхүүнд оногдох үүрэгт нөлөөлж цөм болж буй үйл үг нэмэлт хоёр нь хамтдаа нэгдмэл цогц мэт болж өгүүлэгдэхүүнд тэмдэглэгээ хийж байна. Иймээс нэмэлт аргумент ба өгүүлэгдэхүүн аргумент хоёрыг ялган зааглах шаардлага гардаг нэмэлтүүд нь зөвхөн цөмийн л шууд хяналт хэрэгждэг тийм байрших орчны хүрээнд байдгийг заахын тулд тэдгээрийг /нэмэлтийг/ дотоод аргумент гэж нэрлэдэг. Өгүүлэгдэхүүнүүд нь тэрхүү байрших орчны гадна байдгийг заахын тулд тэдгээрийг /өгүүлэгдэхүүнийг/ гадаад аргумент гэж нэрлэдэг үйлийн хэлцийн/хэлхэцийн М.У/ бүтцийг харахад нь л зохих байрших орчинг бий болгодог гэдэг нь илэрхий. Дотоод аргументууд нь V'-ийн тухайд дотоод аргументууд байх ба гадаад аргументууд нь мөн түүний тухайд гадаад аргумент байна.

Энэ ярьсан зүйл дээр үндэслэн тэмдэглэгээний нөхцлүүдийг нэгтгэн дүгнэж болно. Өмнө дурдсанчлан, нэмэлтүүд нь тэдгээртэй эгч дүүгийн харьцаанд буй цөмийн тусламжтайгаар тэмдэглэгээнд орсон байдаг. Өгүүлэгдэхүүнүүд нь мөн л эгч дүүгийн харьцааны нөхцөлд Ө тэмдэглэгээнд орсон байдаг боловч ялгаа нь гэвэл зөвхөн биш харин цөм ба нэмэлтүүдийн нийлэмж өгүүлэгдэхүүнийг Ө-тэмдэглэгээнд оруулдаг. Өөрөөр хэлбэл, өгүүлэгдэхүүн нь түүнтэй эгч дүүгийн харьцаанд байдаг V'- ийн тусламжтайгаар Ө тэмдэглэгээнд ордог. Мөн шууд ба шууд бус Ө-тэмдэглэгээ гэдэг нэр

томъёог хэрэглэдэг. Шууд Ө-тэмдэглэгээ гэдэг нь цөм нь ганцаараа нэмэлтүүдэд хүлээлгэсэн Ө үүргийг “шууд” тодорхойлдог гэсэн утгаар цөм ба түүний нэмэлтүүдийн хоорондын харьцааг заадаг. Харин шууд бус Ө-тэмдэглэгээ гэдэг нь өгүүлэгдэхүүн нь Ө үүргээ Х-аар дамжуулан “шууд бусаар хүлээн авдаг гэсэн утгаар цөм ба түүний өгүүлэгдэхүүний хоорондын харьцааг заадаг” гэж бичжээ. Түүнчлэн Д.Цэрэнпил аливаа хэлний өгүүлбэр дэх үгсийн дарааллыг Х зартагт хэмжигдэхүүнээр тодорхойлж цөм нь нэмэлтүүдийнхээ өмнө нь буюу дараа нь байдаг тухайлц нь Х-ийнхээ өмнө нь буюу дараа нь байдаг гээд “Дорж ном уншсан гэсэн өгүүлбэрт цөмийн хэмжигдэхүүний дагуу цөм нь ардаа байдаг монгол хэлний тухайд унши-гэсэн үйл үг цөм нь номын гэсэн нэрийн хэлц дагуулынхаа дараа орж, өгүүлэгдэхүүн нь өгүүлбэрийнхээ эхэнд байдаг хэмжигдэхүүнийхээ дагуу Дорж нь үйл хэллэгийнхээ өмнө нь байна” хэмээн бичжээ. /Цэрэнпил 2011:131-144/

Бидний шинжилж байгаа эл асуудлыг түрэг хэлний хүрээнд судалсан Н. Э. Үзүн сэдэгчийг оноогчид болоод сэдэгч оногдох үндэслэгчдийн хооронд үндэслэгчдийн хэлхэцийн бүтцийн талаас бий болох харилцан нөлөөг авч ярихдаа, “үйл үг өгүүлбэрт үйл хэлхэцээр дамжиж шууд бус салаалан холбогдож үйл хэлхэцийн орой болох атал өгүүлэгдэхүүн болох нэрийн хэлхэц өгүүлбэрээс шууд салаална” гээд үйл үгийн үндэслэгчид өгүүлбэрзүйн ялгаатай байрлалд буй хийгээд үйл үгээр өөр өөр сэдэгч оноох харьцаатай байгааг дурдаад хэлхэцийн үндэслэгч сэдэгчийг доорх байдлаар жишээлэн харуулжээ. /Үзүн 2000: 118-119/



НОМЗҮЙ

Chomsky, N. /1986/ *Knowledge of Language its Nature, Origin and Use*, Praeger, New York

Fromkin, V. Rodman, R. and Hyams, N. /2003/ *An Introduction to Language*, Thomson/Heinle

Marantz, A. /1984/ *On the Nature of Grammatical Relations*, MIT Press, Cambridge, Mass

Radford, A. /1988/ *Transformational Grammar*, Cambridge University Press

Radford, A. /1997/ *Syntax: Minimalist Introduction*, Cambridge University Press

Uzun, N. E. /2000/ *Ana Cizgileriyle Evrensel Dilbilgisi ve Turkce*, Multilingual Istanbul

Цэрэнпил, Д. /2011/ *Түгээмэл хэлзүй ба монгол хэл*, Улаанбаатар

SUMMARY

Assignment of thematic roles and relation of thematic roles and sentence subject in English, Mongolian and Turkish

In this article author mentions about one of the interesting issues of the syntactic semantics in the theory of universal grammar, the assignment of thematic roles and theta markings of the sentence subject on English, Mongolian and Turkish facts.